

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/153/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2022 оны 02 дугаар сар

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням  
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: myangnbuum@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа  
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага.....	16
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,

Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.03.01 № 2/922

БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ  
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА  
П.УРТНАСАН ТАНАА

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн,
- Оны эхэнд бүртгэлтэй “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-тай холбоотой 73,699.5 мянган төгрөгийн авлага, 200,000.0 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд барагдуулаагүй байхад зардалд бичиж хаасан,
- Санхүүгийн тайланд бүртгэлтэй 48,782.6 мянган төгрөгийн бараа материалыг актлахдаа устгал хийсэн акт үйлдээгүй,

• 005020544

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн, "Байгалиа дээдлэе" ХХК-аас нийлүүлж, бойжуулалтын талбайд суулгасан 16,880.0 мянган төгрөгийн 4,600 ширхэг модыг зарлагдаж тайлант жилийн зардлаар бүртгэсэн,
- Өвс тэжээл, модны зарцуулалтын анхан шатны баримт хангалтгүй, бүртгэлээр тавих хяналт сул байна.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Тохиолдсон байх", "Үнэлгээ ба хуваарилалт" зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,427,149,800.00</b>	<b>272,203,267.88</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	45.00	00.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	45.00	00.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	45.00	00.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	45.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	117,636,500.00	114,129,692.88
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	117,636,500.00	114,129,692.88
3351	Байгууллагаас авах авлага	00.00	40,430,192.88
3352	Хувь хүмүүсээс авах авлага	117,636,500.00	73,699,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,309,513,255.00	158,073,575.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,309,513,255.00	158,073,575.00
35410	Бичиг хэргийн материал	58,000.00	470,100.00
35420	Аж ахуйн материал	8,294,355.00	8,648,775.00
35470	Бусад хангамжийн материал	1,301,160,900.00	148,954,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>172,981,429.80</b>	<b>340,325,398.40</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	172,981,429.80	340,325,398.40
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	100,850,629.80	268,194,598.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	50,401,200.00	50,401,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,946,799.28	-6,855,420.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,898,400.00	271,898,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,585,900.05	-58,994,233.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,744,453.00	22,744,453.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,041,070.30	-14,373,470.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,023,459.00	1,023,459.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,020,112.57	-1,026,789.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,377,000.00	3,377,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	72,130,800.00	72,130,800.00
39301	Програм хангамж	836,000.00	836,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-836,000.00	-836,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	72,130,800.00	72,130,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,600,131,229.80</b>	<b>612,528,666.28</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>797,117,680.02</b>	<b>200,014,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	797,117,680.02	200,014,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	797,117,680.02	200,014,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	289,660.02	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	14,000.00	200,014,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	796,814,020.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	699,814,020.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	97,000,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>803,013,549.78</b>	<b>412,514,666.28</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	803,013,549.78	412,514,666.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,388,886.00	211,388,886.00
51101	Өмч: - төрийн	211,388,886.00	211,388,886.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	591,236,663.78	200,737,780.28
51210	Өмнөх үеийн үр дүн	591,236,663.78	591,236,663.78
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	388,000.00	388,000.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,600,131,229.80</b>	<b>612,528,666.28</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,307,201,322.88</b>	<b>1,354,928,211.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>162,832,400.00</b>	<b>215,718,833.36</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	162,832,400.00	215,718,833.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	162,832,400.00	215,718,833.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,539,000.00	5,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	160,293,400.00	210,718,833.36
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,144,368,922.88</b>	<b>1,139,209,377.88</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,077,051,222.88	1,062,349,177.88
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	586,878,522.88	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	490,172,700.00	1,062,349,177.88
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	67,317,700.00	76,860,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,317,700.00	76,860,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>595,237,472.76</b>	<b>1,745,427,094.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>595,237,472.76</b>	<b>1,745,427,094.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	398,322,784.48	1,744,469,172.78
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	53,617,220.29	59,862,099.77
210101	Үндсэн цалин	51,332,733.38	57,222,099.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,284,486.91	2,640,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,501,661.11	8,149,518.25
210201	Тэтгэврийн даатгал	4,423,526.50	5,726,318.25
210202	Тэтгэмжийн даатгал	469,115.91	605,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	488,722.73	484,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	95,910.49	121,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,024,385.48	1,211,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	499,886.96	500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	499,886.96	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,322,961.26	54,476,460.00
210401	Бичиг хэрэг	613,500.00	587,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,499,000.00	5,499,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210,461.26	131,980.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	48,257,580.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,039,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,039,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,167,000.00	8,986,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,988,000.00
210604	Урсгал засвар	1,167,000.00	5,998,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	138,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	138,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	318,933,740.00	1,588,110,730.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	318,933,740.00	1,587,438,730.00

**Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	00.00	340,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	99,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210807	Газрын төлбөр	00.00	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,103,314.86</b>	<b>23,884,364.76</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,539,000.00	3,020,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,564,314.86	20,864,364.76
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>196,914,688.28</b>	<b>957,921.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>196,914,688.28</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,425,510.40	00.00
213404	Хөрөнгийн	193,489,177.88	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>457,921.96</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	457,921.96
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>711,963,850.12</b>	<b>-390,498,883.50</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>495,725,465.41</b>	<b>00.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	495,725,465.41	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-495,725,465.41</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>216,238,384.71</b>	<b>-390,498,883.50</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	1,611,800.00	500,136,863.05	713,137,549.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,388,886.00	1,611,800.00	500,136,863.05	713,137,549.05
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	-1,223,800.00	00.00	-1,223,800.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	91,099,800.73	91,099,800.73
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	591,236,663.78	803,013,549.78
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	591,236,663.78	803,013,549.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	591,236,663.78	803,013,549.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-390,498,883.50	-390,498,883.50
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	200,737,780.28	412,514,666.28

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,146,907,922.88</b>	<b>1,188,293,877.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,539,000.00</b>	<b>5,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,539,000.00	5,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,539,000.00	5,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,539,000.00	5,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,144,368,922.88</b>	<b>1,183,293,877.88</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,077,051,222.88</b>	<b>1,106,433,677.88</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	586,878,522.88	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	490,172,700.00	1,106,433,677.88
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>67,317,700.00</b>	<b>76,860,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,317,700.00	76,860,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,146,907,877.88</b>	<b>1,188,293,922.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,146,907,877.88</b>	<b>1,188,293,922.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>949,993,189.60</b>	<b>1,187,336,000.92</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>53,327,560.27</b>	<b>60,141,298.60</b>
210101	Үндсэн цалин	51,043,073.36	57,501,298.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,284,486.91	2,640,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>6,501,661.11</b>	<b>8,159,979.44</b>
210201	Тэтгэврийн даатгал	4,423,526.50	5,736,779.44
210202	Тэтгэмжийн даатгал	469,115.91	605,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	488,722.73	484,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	95,910.49	121,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,024,385.48	1,211,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>499,886.96</b>	<b>500,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	499,886.96	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,260,941.26</b>	<b>6,679,000.00</b>
210401	Бичиг хэрэг	599,500.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,499,000.00	5,499,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	162,441.26	180,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,150,000.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,150,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,167,000.00</b>	<b>2,250,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,750,000.00
210604	Урсгал засвар	1,167,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>138,000.00</b>	<b>500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	138,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>883,948,140.00</b>	<b>1,107,105,722.88</b>

**Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	883,948,140.00	1,106,433,722.88
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	340,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	99,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210807	Газрын төлбөр	00.00	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	00.00	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>196,914,688.28</b>	<b>957,921.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	196,914,688.28	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,425,510.40	00.00
213404	Хөрөнгийн	193,489,177.88	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	457,921.96
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	457,921.96
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	45.00	-45.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	45.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	81,860,200.00	81,402,278.04	457,921.96	99.44
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	81,860,200.00	81,402,278.04	457,921.96	99.44
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	81,360,200.00	80,902,278.04	457,921.96	99.44
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	60,580,800.00	60,141,298.60	439,501.40	99.27
210101	Үндсэн цалин	57,940,800.00	57,501,298.60	439,501.40	99.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,640,000.00	2,640,000.00	-	100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8,178,400.00	8,159,979.44	18,420.56	99.77
210201	Тэтгэврийн даатгал	5,755,200.00	5,736,779.44	18,420.56	99.68
210202	Тэтгэмжийн даатгал	605,800.00	605,800.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	484,600.00	484,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	121,200.00	121,200.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,211,600.00	1,211,600.00	-	100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	500,000.00	500,000.00	-	100.00

**Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210301	Гэрэл, цахилгаан	500,000.00	500,000.00	-	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,679,000.00	6,679,000.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	5,499,000.00	5,499,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	180,000.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,250,000.00	2,250,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,750,000.00	1,750,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	500,000.00	500,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	672,000.00	672,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	340,000.00	340,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	99,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	200,000.00	200,000.00	-	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	500,000.00	500,000.00	-	100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	500,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	81,860,200.00	81,402,278.04	457,921.96	99.44
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	76,860,200.00	76,402,278.04	457,921.96	99.40
132001	Орон нутгийн төсвөөс	76,860,200.00	76,402,278.04	457,921.96	99.40
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	07.00	07.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	-	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>07.00</b>	<b>07.00</b>	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07.00	07.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,106,941,677.88</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,106,941,677.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,106,941,677.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,106,941,677.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,106,941,677.88
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,106,941,677.88</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,106,941,677.88
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,106,941,677.88
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийг холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв хөтлөх, бараа материалыг холбогдох шийдвэрийн дагуу бүртгэлээс хасахдаа устгалын актыг үйлдэж байх, үндсэн хөрөнгийг зөв ангилан бүртгэх зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын дарга П.Уртнасан, 2 дугаар гарын үсгийг 2021.01.01-2021.07.09 хүртэлх хугацаанд нягтлан бодогч Ж.Анхцэцэг, 2021.07.09-ний өдрөөс эхлэн А.Нямхүү нар зурж, нярваар 2021.01.01-2021.05.20 хүртэлх хугацаанд Ц.Отгонбаяр, 2021.07.09-ний өдрөөс хойш нягтлан бодогчоор ажиллаж байсан Ж.Анхцэцэг нар ажиллажээ.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Тус байгууллага нь дарга, нягтлан бодогч, ойн техникч, архив, бичиг хэргийн ажилтан, нярав-ойжуулагч, сахиул-ойжуулагч гэсэн үндсэн 6 орон тооны албан хаагч, 1 гэрээт ажилтантай үйл ажиллагаа явуулж, тайлант онд 25.0 мянган ширхэг улиас, бургасыг харандаа суулгацаар тарьж нутагшуулан тарьсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагад мөрдөх нягтлан бодох бодлогын баримт бичиг байхгүй байна.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 650,893.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,763.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,322.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,745,427.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 26181.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,636.1 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 612,528.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 987,602.6 мянган төгрөгөөр буюу 38.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,427,149.8	272,203.3	(1,154,946.5)
Мөнгөн хөрөнгө	0.0	-	(0.0)
Авлага	117,636.5	114,129.7	(3,506.8)
Бараа материал	1,309,513.3	158,073.6	(1,151,439.7)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	172,981.4	340,325.4	167,344.0
Үндсэн хөрөнгө	222,411.3	422,411.3	200,000.0
Хуримтлагдсан элэгдэл	(49,429.9)	(82,085.9)	(32,656.0)
<b>Нийт хөрөнгө</b>	1,600,131.2	612,528.7	(987,602.6)
Өр төлбөр	797,117.7	200,014.0	(597,103.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	803,013.5	412,514.7	(390,498.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,600,131.2	612,528.7	(987,602.6)

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Тайлант оны эхэнд 117,636.5 мянган төгрөгийн авлагын 74,207.5 мянган төгрөг нь "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-аас шилжүүлэн бүртгэсэн авлага, 655.5 мянган төгрөг нь "Хос соронз" ХХК-аас, 34,636.0 мянган төгрөг нь "Уран энтегра" ХХК-аас, 8,137.5 мянган төгрөг нь "Милл хаус" ХХК-аас авах авлага байжээ. Оны эцэст Баацагаан сумаас 1,650.0 мянга, Баян-Өндөр сумаас 1,172.2 мянга, Баянцагаан сумаас 11,356.3 мянга, Бууцагаан сумаас 4,388.5 мянга, Гурванбулаг сумаас 282.5 мянга, нийт 18,849.5 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлагатай, оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 21,580.7 мянган төгрөгийн шилжүүлгийг авлагаар тусгажээ. "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ -тай холбоотой авлагаас тайлант онд 508.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, оны эцэст 73,699.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Оны эхэнд 1,309,513.2 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй байсан бөгөөд тайлант онд өөрийн болон төсвийн хөрөнгөөр 479,097.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар аймгийн Онцгой байдлын газраас 2,610.5 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч, орон нутгийн хөрөнгө оруулалтаас олгосон 19,900.0 мянган төгрөгийн мод хүлээн авсан байна. Тайлант онд 1,621,145.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан борлуулсан, зарцуулсан бол байгууллагын даргын 2021.08.04-ний өдрийн 25 дугаар тушаалаар 45 нэр төрлийн 33,182.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталж, аймгийн Засаг даргын 2021.06.02-ний өдрийн А/344 тоот захирамжаар

15,200.0 мянган төгрөгийн 95 ширхэг урлон тэжээлийг акталж, оны эцэст 141,193.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Оны эхэнд бүртгэлтэй 222,411.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2021.09.06-ний өдрийн 94 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-т ашиглаж байсан 4 нэр төрлийн 200.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн оны эцэст 422,411.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 281,078.4 мянган төгрөгөөр буурч 310,158.3 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги 2021 оны төсвийн төлөвлөлтийг 172,054.0 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71403 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн хуваарийг 81,860.2 мянган төгрөгөөр баталж, оны дундуур төсөвт өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги орон нутгийн төсвөөс санхүүжих 76,860.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, өөрийн орлогын төлөвлөгөөгөөр 5,000.0 мянган төгрөг оруулахаас мод худалдан борлуулсны орлогоор төлөвлөгөөг бүрэн биелүүлж, 81,402.3 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 457.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар өмнөх оны төвлөрүүлсэн үлдэгдлийн 193,489.2 мянган төгрөг орж, 2020-2021 онд борлуулсан өвс тэжээлийн орлогоор 908.264.0 мянга, мод худалдан борлуулсны орлогоор 5,068.5 мянга, нийт 1,106,821.7 мянган төгрөг орсноос аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 95,000.0 мянган төгрөгийн аймгийн Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж, 4,020.0 мянган төгрөгийг иргэдэд буцаан олгож, өөрийн байгууллагын үйл ажиллагааны зардал, урамшуулалд 10,231.0 мянган төгрөгийг зарцуулан, 5,000.0 мянган төгрөгийг үндсэн дансанд шилжүүлэн, өвс тэжээл худалдан авахад 970,991.9 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 21,580.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 3/12 дугаар тогтоолоор Сум дундын Ойн ангийн ажилчдын ажлын байр барихад 32,000.0 мянган төгрөгийн төсөв баталж, “Баянцогт дэлгэрэх” ХХК-тай Сум дундын Ойн ангийн дарга 2021.07.20-ний өдөр 42,000.0 мянган төгрөгийн “Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги, аюулгүй нөөцийн газрын барилгын ажлын туслан гүйцэтгэх гэрээ”-г байгуулжээ. Барилгын ажлын гүйцэтгэлийн санхүүжилт аймгийн Сум дундын Ойн ангиар дамжаагүй болно.

“Баянцогт дэлгэрэх” ХХК-ийн харилцах дансанд 2021 оны 10-11 сард нийт 5 удаагийн гүйлгээгээр “Наран мандал энтерпрайзес” ХХК-аас 50,000.0 мянган төгрөгийн шилжүүлэг хийсэн ба үүнээс 32,000.0 мянган төгрөг нь аймгийн Засаг даргын 2021 оны 3/12 дугаар тогтоолоор шилжүүлсэн хөрөнгө оруулалт гэсэн тайлбарыг аймгийн ХОХБТХ-ийн мэргэжилтэн өгсөн болно.

Оны эцэст “Баянцогт дэлгэрэх” ХХК –д 10,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан ба тус барилгын ажлыг улсын комисс хүлээн аваагүй байна.

Баянхонгор аймагт өвөлжилт, хаваржилт хүндэрч аймгийн Засаг даргын шийдвэрээр өвс тэжээлийг татан авч, Сум дундын Ойн ангиар дамжуулан олгосон бөгөөд өвс тэжээлийн тооцооны анхан шатны баримт хангалтгүй, бүртгэл хангалтгүй байгаа ба тус асуудлыг санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад цаг хугацаа, хүн хүчний бололцоо хязгаарлагдмал байсан тул өвс, тэжээлийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох шалгуулах шаардлагатай байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2021 онд 28 ажил арга хэмжээ төлөвлөж ажилласнаас 25 ажил биелж 3 ажил нь ковидтой холбоотойгоор хойшлогдсон ба аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс биелэлтийг 97 хувиар дүгнэжээ.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн дүн нь аудитаар тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн, барагдаагүй авлага, төлөгдөөгүй өглөгийг зардлын бичилтээр хаасан, бараа материалын хөдөлгөөнийг анхан шатны баримтад үндэслэн бүрэн хөтлөөгүй, орон нутгийн хөрөнгө оруулалтаар ирж тариалалт хийсэн модыг тайлант хугацааны зардлаар бүртгэсэн, тооллогын бүртгэл санхүүгийн тайлангаас зөрүүтэй байхад нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4, 13.7 дахь заалт, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Үнэлгээ”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөв.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг шалгав.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,943,975.5 мянган төгрөгийн 98 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс байгууллагын даргын 35,37, 38 тоот тушаалыг мэдээлээгүй, 6 дугаар сарын 81,900.0 мянган төгрөгийн 2 зарлагын гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Тайлант онд бичиг хэргийн зардалд батлагдсан 1,000.0 мянган төгрөгийг бүрэн зарцуулж "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.9 дэх "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тус байгууллага түүвэрт хамрагдсан тул зөвлөмж өгөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан болон мод үржүүлгийн хашаанд тарьж ургуулан хувь хүмүүс, аж ахуйн нэгж, байгууллагуудад олгож байгаа модны зарцуулалт, үнийг дансанд төвлөрүүлж байгаад анхаарал хандуулах нь зүйтэй байна.

Өвс, тэжээлийн тооцоотой холбоотой асуудлыг аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА-аар шалгуулах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 435,129.2 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн тайланд 290,579.5 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 2,925.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 91,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 50,124.7 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлэв.

#### 4.1 Залруулсан алдаа

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны санхүүгийн тайланд нийт 290,579.5 мянган төгрөгийн дараах залруулгыг хийлээ. Үүнд:

1. Санхүүгийн тайланд бүртгэлтэй 200,000.0 мянган төгрөгийн өглөгийг төлж барагдуулаагүй байхад өглөгийг нягтлан бодох бүртгэлийн бичилтээр хаасан.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд 200,000.0 мянган төгрөгийн өглөгийг залруулав.

2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн, "Байгалиа дээдлээ" ХХК-аас нийлүүлсэн 19,900.0 мянган төгрөгийн 5,800 ширхэг модноос 3,020.0 мянган төгрөгийн 1,200 ширхэг модыг худалдан борлуулж, 16,880.0 мянган төгрөгийн 4,600 ширхэг модыг бойжуулалтын талбайд суулгасан байхад модыг зарлагдаж тайлант жилийн зардлаар бүртгэсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бойжуулалтын талбайд тарьж ургуулсан 16,880.0 мянган төгрөгийн 4,600 ширхэг модыг эргэлтийн хөрөнгөд орлогоор нэмж залруулав.

3. Оны эхэнд бүртгэлтэй 74,207.5 мянган төгрөгийн "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ -аас шилжүүлэн бүртгэсэн авлагаас тайлант онд 508.0 мянган төгрөг барагдсан байхад нягтлан бодогч 74,207.5 мянган төгрөгийн авлагыг хаасан зөрчилтэй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд 74,207.5 мянган төгрөгийг авлагаар залруулан бүртгэв.

#### 4.2 Төлбөрийн акт

1. Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.12.22-ний өдрийн А/777 дугаар захирамжаар аюулгүйн нөөцөд өвс, тэжээл татан байршуулах, малчдад өвс, тэжээл худалдан борлуулах ажлыг цагийн хүнд үед ажилласан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох шийдвэрийн дагуу байгууллагын даргын шийдвэрээр албан хаагчдад урамшуулал олгохдоо тухайн цаг үед ажиллаагүй албан хаагчдад 2,925.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь аюулгүйн нөөцөд өвс, тэжээл татан байршуулах, малчдад өвс, тэжээл худалдан борлуулах ажлыг цагийн хүнд үед ажилласан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох аймгийн Засаг даргын 2021 оны А/777 дугаар захирамжийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан хаагчдаар 2,925.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

1. Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжийн дагуу аймгийн Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн 81,900.0 мянган төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, байгууллагын даргын гаргасан хөрөнгө зарцуулах тухай 9,600.0 мянган төгрөгийн 3 тухшаалыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага .....бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөв.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.06.02-ний өдрийн А/344, байгууллагын даргын 2021.08.04-ний өдрийн 25 дугаар тушаалаар санхүүгийн тайланд бүртгэлтэй гэр, мод, урлон тэжээл зэрэг 48,782.6 мянган төгрөгийн бараа материалыг актлахдаа устгал хийсэн акт үйлдээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Холбогдох шийдвэрээр хөрөнгө актлахдаа комисс томилж, хөрөнгийг устгал хийсэн акт үйлдэж, анхан шатны баримтад хавсаргаж байх.

##### 2. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд модон өлгүүр, туг, хүлэмж, хулдаас зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй хөрөнгө бүртгэлтэй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Холбогдох газарт асуудлыг тавьж, хөрөнгийн ангиллыг залруулан бүртгэн, цаашид Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын заалтын дагуу хөрөнгийн ангиллыг нягтлан бодох бүртгэлд зөв тусгах.

##### 3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мод үнэгүй олгох тухай байгууллагын даргын 2021 оны 10, 29 дүгээр тушаалуудыг хавсралтаар гаргаагүй, үнэтэй олгосон модны тайлан мэдээг гаргаагүй, модны бүртгэл хөтлөлт, түүнд тавих хяналт хангалтгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Модны насжилтын бүртгэлийг байгууллагын нягтлан бодох бүртгэлд мөрдөх бодлогын баримт бичигт нарийвчлан тусган, бүртгэлийг зөв тусгах, үнэ төлбөргүй олгосон модны тоо ширхэг, олгох байгууллагын нэрийг тушаалын хавсралтаар баталсны үндсэн дээр олгож байх

##### 4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Нярав бараа материалын тайлангийн эхний үлдэгдлийг сар бүр зөрүүтэй гаргасан, өвс тэжээл худалдан борлуулсан 2021 оны анхан шатны баримтуудыг 2020 оны баримттай хамт үдсэн байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Няравын тайланг дахин гаргуулж, анхан шатны баримтыг он тус бүрээр үдэж, байгууллагын архивт хүлээлгэн өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/мянган төгрөгөөр/									
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги	9	435,129.2	3	290,579.50	1	2,925.00	1	91,500.0	4	50,124.7

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠐᠒ сарын ᠒᠑ өдөр

Дугаар 89/᠒᠐᠒᠒/᠒᠒᠑᠑  
᠑᠒᠒ - 2022/153/᠒᠒ - ᠑᠒᠒ - ᠒᠒᠑

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжийн дагуу аймгийн Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн 81,900,000 төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, байгууллагын даргын хөрөнгө зарцуулах тухай 9,600,000 төгрөгийн 3 тушаалыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг байгууллага ... долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8 дахь "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан, зогсоож, давтан гаргуулахгүй үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн бол албан шаардлага өгнө" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

᠒᠐᠒᠒/᠒᠒᠑᠑

1. Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нэмэлт санхүүжилтийн данснаас аймгийн Онцгой байдлын газарт шилжүүлсэн 81,900,000 /Наян нэгэн сая есөн зуун мянган/ төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, байгууллагын даргын 9,600,000 /Есөн сая зургаан зуун мянган/ төгрөгийг зарцуулах 3 тушаалыг байршуулах.
2. Аудитаар өгсөн 91,500,000 /Ерэн нэгэн сая таван зуун мянган/ төгрөгийн албан шаардлагын биелэлтийг, холбогдох нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>-т ирүүлэхийг Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн дарга П.Уртнасан<sup>2</sup>, нягтлан бодогч А.Нямхүү нарт хариуцуулав<sup>3</sup>.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор хот, 1 дүгээр баг, Нутгийн удирдлагын ордон. Утас: 7044-2584

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1 - "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүрэгээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"

<sup>3</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 86/

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.12.22-ний өдрийн А/777 дугаар захирамжаар аюулгүйн нөөцөд өвс, тэжээл татан байршуулах, малчдад өвс, тэжээл худалдан борлуулах хүнд цаг үед ажилласан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох шийдвэрийн дагуу байгууллагын даргын 2021.12.23-ний өдрийн 38 дугаар тушаалаар албан хаагчдад урамшуулал олгохдоо тухайн цаг үед ажиллаагүй албан хаагчдад 2,925,000 төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.12.22-ний өдрийн А/777 дугаар захирамжийн 2-т "Аймгийн хэмжээнд 2020-2021 оны зуншлага тааруу гандуу байсны улмаас өвөлжилт, хаваржилт хүндэрч, аюулгүйн нөөцөд өвс, тэжээл татан байршуулах, малчдад өвс, тэжээл худалдан борлуулах ажлыг цагийн хүнд хэцүү үед ажилласан албан хаагчдад мөнгөн мөнгөн урамшуулал олгох" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

005050225  
Alban bichig 2022 төлбөрийн акт

1. Аюулгүйн нөөцөд өвс, тэжээл татан байршуулах, малчдад өвс, тэжээл худалдан борлуулах хүнд цаг үед ажиллаагүй албан хаагчдаар 2,925,000 /Хоёр сая есөн зуун хорин таван мянган/ төгрөгийг төлүүлж, төлбөрийг бусад татвар хураамжийн 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн дарга П.Уртнасан, нягтлан бодогч А.Нямхүү нарт хариуцуулав<sup>2</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>3</sup>:**


БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН

ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

А.ЦЭЭНЯМ

Б.ДОЛЖМАА




<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

<sup>3</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын  
газрын 2022 оны 3-р сарын 15-ний  
өдрийн 86/А0560238/БНА-2022/153/НА-  
СТА-ТШЗ тоот албан шаардлагын хавсралт



№	Албан хаагчийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/
1	М.Мөнгөнцэцэг	900,000
2	С.Батжаргал	900,000
3	Т.Эрдэнэзул	225,000
4	А.Нямхүү	900,000
<b>ДҮН</b>		<b>2,925,000</b>

---oOo---